

Сургуулийн болон МСҮТ-ийн нийгмийн ажилтан, Албан бус/насан туршийн боловсролын багш нарт зориулсан сургалтын тайлан.

2014.02.17

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн нийгмийн ажилтанууд, Албан бус /насан туршийн боловсролын багш нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, чадваржуулах, тэдний хүүхэдтэй ажиллах арга барилыг сайжруулах, ёс зүйн төлөвшлийг дээшлүүлэх зорилгоор 2 өдрийн сургалтыг энэ сарын 13-14-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Сургалтанд боловсролын нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын нийт 54 багш оролцож сургалтын эхний өдрөөр Хүүхдийн эрх үүрэг, Хүүхдийн хүмүүжил төлөвшил, хүүхдийг таньж мэдэх мэдрэмж , хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд зэрэг сургалтыг боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгийн багш Н. Хандсүрэн удирдан явуулсан ба дараагийн өдөр Хүүхэдтэй ажиллах арга зүй, боловсролын нийгмийн ажилтны үүрэг, амьдрах ухааны сургалтууд хөтөлбөрийн дагуу явагдаж сургалтын төгсгөлд сургалтанд оролцогчдод сертификат гардууллаа.

Сургалтын үеэр боловсролын нийгмийн ажилтануудад цаг үеийн талаархи мэдээллийг хийж , гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хамтран ажиллах саналыг авлаа.

Сургалтыг Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Аймгийн Боловсролын газар, ДЗОУБ-ын Сэлэнгэ НХХөтөлбөртэй хамтран зохион байгуулж бичгийн хэргийн зардалд 55.0 , хөнгөн цайны зардалд 240.0 төгрөг зарцууллаа.

Энэ удаагийн сургалтанд Сант, Орхонтуул 9-н жил, Хэрхийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтанууд оролцсонгүй.

Тайлан гаргасан: Ахлах мэргэжилтэн

Д. Оюунжаргал

Сургалтын нээлтийн үйл ажиллагаа



Сургалтын үеэр



Сургалтын 2 дахь өдөр боловсролын нийгмийн ажилтанууд Хүүхэдтэй ажиллах арга барилаа дээшлүүлж, мэргэжил арга зүйд суралцахын зэрэгцээ харилцан бие биенээсээ суралцлаа.



Насан туршийн боловсролын багш нар амьдрах ухааны сургалтаар иргэдэд олгох чадварыг дээшлүүллээ.



Сургалтанд оролцогчдод сертификад гардууллаа.



Сургалтын багийнхан

